



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.04.20 № 569  
танай \_\_\_\_\_-ы № \_\_\_\_\_-т

### Г ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН 7 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Хэнтий аймгийн 2025 оны нэгдсэн төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт *3д* хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ХЭНТИЙ АЙМГИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

АУДИТЫН КОД: ХЭА-2026/02-22/СТА-НА-НТГ

Чингис хот 2026 он  
Цахим хуудас: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

**Дарга, тэргүүлэх аудитор:** Ж.Ганбаатар  
Утас: 70562112

**Аудитын менежер:** Д.Оюунтуяа  
Утас: 99775390

**Ахлах аудитор:** Г.Энх-Амгалан  
Утас: 91119424

**Аудитор:** Н.Туяа

**Аудитор:** Х.Еркегүл

**Аудитор:** Д.Эрдэнэтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
[khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn) хаягаар авна уу.

Тайланг  
бэлтгэсэн:  
Хэнтий аймаг  
дахь Төрийн  
аудитын газар

Дарга, тэргүүлэх  
аудитор  
Ж.Ганбаатар

Аудитын менежер  
Д.Оюунтуяа

Ахлах аудитор:  
Г.Энх-Амгалан  
Аудитор:  
Н.Туяа  
Х.Еркегүл  
Д.Эрдэнэтуяа

2026 оны 04 сар

Аудитын тайлан,  
дүгнэлттэй  
холбоотой  
асуудлаар нэмж  
тодруулах, асууж  
лавлах зүйл  
байвал 70562147,  
70562112  
дугаарын утас,  
[khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)  
мн хаягаар  
харилцана уу.

ХАЯГ:Хэнтий  
аймгийн Хэрлэн  
сум, аймгийн  
ЗДТГ-ын байр, 322  
тоот

## АГУУЛГА

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ .....	4
Аудитын зорилт: .....	5
Хамарсан хүрээ: .....	5
Аудитын арга зүй:.....	5
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:.....	5
Үндсэн мэдээлэл .....	6
БҮЛЭГ 1. ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ 129 ХУВИАР БИЕЛҮҮЛСЭН НЬ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ БОЛОМЖ БАЙНА. ....	6
БҮЛЭГ 2. ТӨСВӨӨС 2,117.4 САЯ ТӨГРӨГ БУЮУ НИЙТ ЗАРДЛЫН 2 ХУВИЙГ ХУУЛЬ, ТОГТООМЖ ЗӨРЧИЖ ЗАРЦУУЛСАН БАЙНА. ....	15
БҮЛЭГ 3. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ, ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛААГҮЙТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ ИЛЭРСЭЭР БАЙНА. ....	25
Аудитын илрүүлэлт:.....	28
Аудитын дүгнэлт.....	29
Аудитын зөвлөмж.....	29
Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	30
Аудит хийгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	31
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал .....	32

**Хавсралтын товьёг**

Хавсралт №1	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
Хавсралт №2	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**Хүснэгтийн товьёг**

Хүснэгт №1	Орлогын төлөвлөлт
Хүснэгт №2	Орон нутгийн төсвийн тодотгол
Хүснэгт №3	Төсвийн тодотголоор урьд оны үлдэгдлийн төлөвлөлт
Хүснэгт №4	Төсвийн зарлагад хийсэн тодотгол
Хүснэгт №5	Орон нутгийн төсвийн эх үүсвэр
Хүснэгт №6	Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт №7	Орлогын гүйцэтгэл сумдаар
Хүснэгт №8	Сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл
Хүснэгт №9	Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт №10	Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт №11	Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт №12	Төсвийн гүйцэтгэл, хөтөлбөр арга хэмжээний ангиллаар
Хүснэгт №13	Төсвийн зарлагын гүйцэтгэл, эдийн засгийн ангиллаар
Хүснэгт №14	Батлагдсан орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт №15	Нэмэлт төсвийн санхүүжилтийн эх үүсвэр
Хүснэгт №16	Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт
Хүснэгт №17	ОНХС-ийн төсөл арга хэмжээний хэрэгжилт
Хүснэгт №18	Хоршоог хөгжүүлэх сангийн зарцуулалт
Хүснэгт №19	Орон нутгийн төсвийн 2025 оны үр дүнгийн үзүүлэлт
Хүснэгт №20	Харьяа байгууллагын зөрчлийн нэгтгэл

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДҮАХ	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
АТӨЯХ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгсэл
БОНАТ	Борлуулалтын орлогод ногдох албан татвар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАХ	Төсөл арга хэмжээ
МУ	Монгол улс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮҮЗАУс	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус
ҮХХБО	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2026 оны 04 дугаар сарын 20

Дугаар А/10

Чингис хот

Аудитын тайлан  
баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсэг, 2025 оны А/161 дугаар тушаалаар баталсан “Аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 6.3, 6.3.1 дэх хэсэг, 2025 оны А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. “Хэнтий аймгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Хэнтий аймгийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд байгууллагын цахим хуудаст нийтэлж, иргэд, олон нийтэд түгээхийг ахлах аудитор /Г.Энх-Амгалан/-д даалгасугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 20 -ны өдрийн дотор тус тус Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэнтий аймгийн Засаг дарга /Д.Аюурбуны/-д зөвлөсүгэй.
4. Аудитын шийдвэрийг статистик мэдээнд бүртгэж Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт тогтоосон хугацаанд хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, улирал бүр байгууллагын цахим хуудаст нийтэлж, иргэд, олон нийтэд түгээж ажиллахыг ахлах аудитор /Г.Энх-Амгалан/-д үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Д.Оюунтуяа/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## АУДИТЫН ТАЙЛАН

### Ерөнхий зүйл

**Аудитын нэр:** “Хэнтий аймгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”

**Аудитын код:** ХЭА-2026/02-22/СТА-НА-НТГ

### Аудитын хийх үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025 оны “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дугаар тушаал, аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

### Аудитын зорилт:

Хэнтий аймгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн ИТХ болон Засаг даргад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Орон нутгийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх
2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, үнэн зөв тайлагнасан эсэх
3. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан эсэх

### Хамарсан хүрээ:

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, NS6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэлээ. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулж, аудитын горим сорилыг хэрэгжүүлэв. Үүнд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд болон бусад холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, судалгаа, тоон мэдээлэл авах, түүвэрлэлт, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ, харьцуулалт хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа. Аудитад аймгийн ТЕЗ-ийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэнцэл, аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, татварын орлогын гүйцэтгэлийн мэдээ болон бусад холбогдох баримт материалыг хамруулав.

### Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, судалгаа тодруулга авах, баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг аргыг ашиглахаас гадна аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- ✓ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- ✓ Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- ✓ Хэнтий аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө
- ✓ Хэнтий аймгийн Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
- ✓ Аймаг болон сумдын төсвийг баталсан ИТХ-ын тогтоолууд
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд
- ✓ Бусад дүрэм журам, тушаал, шийдвэр

### Үндсэн мэдээлэл

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Хэнтий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 27,305.8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 16,234.2 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Хэнтий аймгийн 2025 оны төсвийг анх батлахдаа татварын орлого 38,194.7 сая төгрөг, татварын бус орлого 2,851.8 сая төгрөг, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 40,849.4 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 23,761.1 сая төгрөг, урьд оны үлдэгдэл 1,402.3 сая төгрөг нийт орлого 123,822.2 сая төгрөгөөр баталсан байна.

Хэнтий аймгийн төсвийн урсгал зардалд 82,923.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 36,414.5 сая төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлд 4,483.8 сая төгрөг, нийт зардлыг 123,822.2 сая төгрөгөөр баталсан байна.

Улсын Их Хурлаас 2025 оны 7 дугаар сард Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар орон нутгийн төсөвт тодотголыг 1 удаа хийсэн байна.

### **БҮЛЭГ 1. ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ 129 ХУВИАР БИЕЛҮҮЛСЭН НЬ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХ БОЛОМЖ БАЙНА.**

#### *Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломж байна.*

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд төсвийн суурь орлогыг 35,158.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж Сангийн яамд хүргүүлснийг 1,869.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 37,028.1 сая төгрөгөөр, улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгт 40,849.4 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 23,761.1 сая төгрөгөөр тооцож, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 101,638.6 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

#### Орлогын төлөвлөлт

Хүснэгт 1.

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төсвийн төсөлд өгсөн санал	Сангийн яамнаас хянасан	Зөрүү
<b>Нийт орлого</b>	<b>48,691.2</b>	<b>35,158.4</b>	<b>37,028.1</b>	<b>1,869.7</b>
Татварын орлого	42,750.4	32,358.4	34,205.8	1,847.4
Татварын бус орлого	5,708.7	2,600.0	2,822.3	222.3
Хөрөнгийн орлого	232.1	200.0	200.0	-

Өмнөх оны орлогын гүйцэтгэл 48,691.2 сая төгрөг байхад 2025 оны төсвийн саналыг 13,532.8 сая төгрөгөөр бага буюу 35,158.4 сая төгрөгөөр боловсруулсан нь орлогыг өмнөх оны гүйцэтгэл, бодит тооцоо судалгаанд үндэслэн нэмэгдүүлэх боломжийг бүрэн дайчилж төлөвлөөгүй байна.

Хэнтий аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 05 тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлогыг 41,022.3 сая, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 40,849.4 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг 23,761.1 сая, бусад эх үүсвэрээр 2,851.8 сая, өмнөх оны үлдэгдэл 15,337.6 сая, нийт эх үүсвэр 123,822.2 сая төгрөгөөр, 2025 онд аймгийн төсвийн зарлагыг нийт 123,822.2 сая төгрөгөөр баталжээ.

**Орон нутгийн төсвийн тодотголоор орлогыг нэмэгдүүлсэн боловч, гүйцэтгэлээр 10,509.3 сая төгрөгөөр давж биелсэн байна.**

Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр Хэнтий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 13,543.6 сая төгрөг, улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 7,526.9 сая төгрөгөөр бууруулан баталсантай холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалтын дагуу орон нутгийн төсөвт тодотгол хийсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогыг баталсан дүнгээс 4.5 хувь буюу 5,633.8 сая төгрөгөөр бууруулж 118,188.4 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

### Орон нутгийн төсвийн орлогын тодотгол.

Хүснэгт 2.

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он		
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зөрүү
<b>А</b>	<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>4</b>	<b>5=4-3</b>
	<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>107,289.3</b>	<b>123,822.2</b>	<b>118,188.4</b>	<b>(5,633.8)</b>
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>48,691.2</b>	<b>41,022.3</b>	<b>45,050.9</b>	<b>4,028.6</b>
<b>А</b>	<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>48,459.1</b>	<b>40,822.3</b>	<b>44,850.9</b>	<b>4,028.6</b>
<b>1</b>	<b>Татварын орлого</b>	<b>42,750.4</b>	<b>38,194.7</b>	<b>40,759.8</b>	<b>2,565.1</b>
<b>1.1</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>31,926.7</b>	<b>30,537.6</b>	<b>32,780.7</b>	<b>2,243.1</b>
<b>1.1.1</b>	Хувь хүний орлогын албан татвар	28,199.3	25,277.6	27,638.7	<b>2,361.1</b>
<b>1.1.2</b>	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,009.0)	(1,300.0)	(1,418.0)	<b>(118.0)</b>
<b>1.1.3</b>	ААН-ийн орлого	4,736.4	6,560.0	6,560.0	-
<b>1.2</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>1,946.3</b>	<b>1,027.0</b>	<b>1,533.3</b>	<b>506.3</b>
<b>1.3</b>	<b>Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар</b>	<b>809.0</b>	<b>808.0</b>	<b>808.0</b>	-
<b>1.3.1</b>	Тусгай зориулалтын орлого	-	-	-	-
<b>1.3.2</b>	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	692.8	808.0	808.0	-
<b>1.4</b>	<b>Бусад татвар /төлбөр хураамж/</b>	<b>8,068.4</b>	<b>5,057.8</b>	<b>5,637.8</b>	<b>580.0</b>
<b>2</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>5,708.7</b>	<b>2,627.6</b>	<b>4,091.0</b>	<b>1,463.4</b>
<b>Б</b>	<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>232.1</b>	<b>200.0</b>	<b>200.0</b>	-
<b>Б-1</b>	Хөрөнгө борлуулсны орлого	232.1	200.0	200.0	-
<b>В</b>	<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>58,598.1</b>	<b>82,799.9</b>	<b>73,137.6</b>	<b>(9,662.3)</b>
<b>В-1</b>	ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	17,914.6	23,761.1	16,234.2	<b>(7,526.9)</b>
<b>В-2</b>	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	38,777.6	40,849.4	27,305.8	<b>(13,543.6)</b>
<b>В-5</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,905.9</b>	<b>2,851.8</b>	<b>2,522.9</b>	<b>(328.9)</b>
<b>В-6</b>	<b>Урьд оны үлдэгдлээс</b>	<b>-</b>	<b>15,337.6</b>	<b>27,074.7</b>	<b>11,737.1</b>

Төсвийн тодотгол орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлж, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, ОНХС-ийн дэмжлэгийг бууруулсан байна. Үүнд:

- Татварын орлогыг 4,028.5 сая төгрөг, татварын бус орлогыг 1,463.4 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 11,737.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж;

- Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 13,543.6 сая төгрөг, ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 7,526.9 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Аймгийн төсөвт урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 6,051.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Замын сангийн эхний үлдэгдлийг 105.1 сая төгрөгөөр, малыг эрсдэлээс хамгаалах сангийн эхний үлдэгдлийг 115.4 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

Төсвийн тодотголоор урьд оны үлдэгдлийн төлөвлөлт

Хүснэгт 3.

/сая төгрөг/

№	Байгууллагын төрөл	2024 оны жилийн эцсийн үлдэгдэл	Анхны тогтоол 2024.12.19 №05	Зөрүү	Төсвийн тодотгол 2025.07.29 №02	Зөрүү
		1	2	3=2-1	4	5=4-1
1	Аймгийн төсвийн урьд оны үлдэгдэл	5,798.3	1,325.0	(4,473.3)	5,798.3	-
2	Замын сангийн урьд оны үлдэгдэл	118.6	13.5	(105.1)	13.5	105.1
3	Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл	239.4	63.8	(175.6)	239.4	-
4	МЭХС-ийн урьд оны үлдэгдэл	115.4		(115.4)	-	115.4
	<b>Нийт</b>	<b>6,271.6</b>	<b>1,402.3</b>	<b>(4,869.3)</b>	<b>6,051.2</b>	<b>220.5</b>

Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэгддэг ТТЗ болон ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлттэй холбоотой нийт 885.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 83.5 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 802.0 сая төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

- Орон нутгийн ерөнхий орлого, ХХС, ОНХС-ийн урьд оны үлдэгдлийг Батноров 31.0 сая төгрөг, Батширээт сум 28.5 сая төгрөг, Баян-Адарга сум 22.4 сая төгрөг, Баян-Овоо сум 7.5 сая төгрөг, Баянмөнх сум 38.4 сая төгрөг, Баянхутаг сум 4.0 сая төгрөг, Биндэр сум 51.7 сая төгрөг, Бор-Өндөр сум 54.0 сая төгрөг, Галшар сум 7.5 сая төгрөг, Дадал сум 60.9 сая төгрөг, Дархан сум 26.3 сая төгрөг, Дэлгэрхаан сум 34.0 сая төгрөг, Мөрөн сум 5.7 сая төгрөг, Норовлин сум 11.4 сая төгрөг, Цэнхэрмандал сум 9.0 сая төгрөг, Өлзийт тосгон 17.9 сая төгрөг, Өмнөдэлгэр сум 65.2 сая төгрөг, нийт 475.4 сая төгрөгөөр дутуу баталж эхний үлдэгдлийг бүрэн төлөвлөөгүй;
- Хэрлэн сум 83.5 сая төгрөг, Биндэр сум 23.0 сая төгрөг, Баян-Адарга сум 0.6 сая төгрөг, Мөрөн сум 1.0 сая төгрөг, нийт 108.1 сая төгрөгөөр урьд оны үлдэгдлээс илүү төлөвлөж, баталсан;
- Өмнөдэлгэр сум нь орон нутгийн төсвийг 271.9 сая төгрөгөөр алдагдалтай баталсан;

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгах зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн.

- Батширээт тохижилт, Жаргалтхаан сумын тохижилт үйлчилгээ, Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ууд нь үйлдвэрлэл үйлчилгээний санхүүгийн төлөвлөгөө боловсруулж зохих байгууллагаар батлуулаагүй, сумын Засаг даргатай гэрээ байгуулаагүй, гэрээний хэрэгжилтийг дүгнүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. *Жаргалтхаан, Мөрөн сум нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжих 2 төсөл арга хэмжээний төсөвт өртгийг тэнцүү хувааснаас бууруулж төлөвлөсөн байна.*

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох шаардлага хүргүүлсэн.

**Орон нутгийн төсвийн тодотголоор зардлыг 5,633.8 сая төгрөгөөр бууруулсан боловч, гүйцэтгэлээр 16,172.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.**

Орон нутгийн төсвийн тодотголоор зарлагад дараах өөрчлөлтүүд орсон байна. Төсвийн зарлагад тодотгол хийсэн байдлыг жилийн эцсийн гүйцэтгэлтэй авч үзвэл:

#### Төсвийн зарлагад хийсэн тодотгол

Хүснэгт 4.

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он			
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
А	1	2	4	5	6=4-5
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>93,909.3</b>	<b>123,822.2</b>	<b>118,188.4</b>	<b>102,015.9</b>	<b>16,172.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>65,807.2</b>	<b>82,923.9</b>	<b>81,168.6</b>	<b>73,134.9</b>	<b>8,033.7</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>63,117.6</b>	<b>81,181.0</b>	<b>79,601.4</b>	<b>71,834.2</b>	<b>7,767.2</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,064.0	27,929.6	27,542.8	25,787.5	1,755.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,569.8	3,491.3	3,444.5	3,155.7	288.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,393.5	24,882.6	22,237.5	20,000.7	2,236.8
Хангамж, бараа материалын зардал	1,394.7	1,457.1	1,569.9	1,235.3	334.7
Нормативт зардал	743.2	98.5	99.5	57.4	42.1
Эд хогшил, урсгал засварын зардал	2,845.7	2,967.9	3,251.0	2,889.9	361.1
Томилолт, зочны зардал	676.8	784.1	890.6	717.5	173.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,704.9	12,316.2	13,137.6	11,762.0	1,375.6
Бараа үйлчилгээний бусад зардал	6,724.9	7,253.8	7,428.0	6,228.2	1,199.8
<b>ТАТААС</b>	<b>399.0</b>	<b>321.7</b>	<b>15.0</b>	<b>2.0</b>	<b>13.0</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	8.0	17.7	15.0	2.0	13.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	391.0	304.0	-	-	-
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,290.6</b>	<b>1,421.2</b>	<b>1,552.2</b>	<b>1,298.7</b>	<b>253.5</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	225.2	267.5	278.0	270.6	7.4
Бусад урсгал шилжүүлэг	2,065.4	1,153.7	1,274.2	1,028.1	246.1
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,029.7</b>	<b>36,414.5</b>	<b>32,463.8</b>	<b>26,463.3</b>	<b>6,000.5</b>
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>1,072.4</b>	<b>4,483.8</b>	<b>4,556.1</b>	<b>2,417.7</b>	<b>2,138.4</b>

Нийт зардлыг тодотголоор 5,633.8 сая төгрөгөөр бууруулж баталсан ч гүйцэтгэлээр 16,172.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Тухайлбал:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хөрөнгийн зардлыг 46.8- 3,950.8 сая төгрөгөөр бууруулж баталсан боловч гүйцэтгэлээр 288.7– 6,000.5 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Хангамжийн бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг 106.5 – 821.4 сая төгрөгөөр нэмж баталсан боловч 173.1-1,375.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Энэ нь сангийн яамнаас зардлыг хязгаарласантай холбоотой байна.

**Санхүүгийн дэмжлэг, татварын болон татварын бус орлого, сумаас аймагт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.**

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар аймаг, сумдын ИТХ-аар нийт 118,188.4 сая төгрөгийн эх үүсвэрийг баталжээ. Үүнд: Эхний үлдэгдлээс 27,074.7 сая төгрөг, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 27,305.8 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 16,234.2 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 2,522.9 сая төгрөг, татварын орлогоос 40,759.8 сая төгрөг, татварын бус орлогоос 4,091.0 сая төгрөг, хөрөнгийн орлогоос 200.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр татварын орлого 51,269.3 сая төгрөг, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 27,305.8 сая төгрөг, ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг 16,077.6 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 2,689.2 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 255.2 сая төгрөг, татварын бус орлого 6,696.4 сая төгрөг, нийт 104,293.5 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урьд оны үлдэгдлээс 27,074.7 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн эх үүсвэр

Хүснэгт 5.

/сая төгрөг/

Орлогын төрөл	Баталсан	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>44,850.9</b>	<b>57,965.7</b>	<b>-13,114.8</b>	<b>129%</b>
Татварын орлого	40,759.8	51,269.3	-10,509.4	126%
Татварын бус орлого	4,091.0	6,696.4	-2,605.4	164%
<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>200.0</b>	<b>255.2</b>	<b>-55.2</b>	<b>128%</b>
Хөрөнгө борлуулсны орлого	200.0	255.2	-55.2	128%
<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>73,137.6</b>	<b>46,072.6</b>	<b>27,065.0</b>	<b>63%</b>
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	27,305.8	27,305.8	0.0	100%
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	16,234.2	16,077.6	156.6	99%
Бусад тусламж /эхний үлдэгдэл/	27,074.7	0.0	27,074.7	0%
Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,522.9	2,689.1	-166.2	107%
<b>ДҮН</b>	<b>118,188.4</b>	<b>104,293.5</b>	<b>13,895.0</b>	<b>88%</b>

Татварын орлого:

Тайланд онд орон нутгийн төсвийн татварын орлогыг 40,759.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 51,269.1 сая төгрөгийг төвлөрүүлэн төлөвлөгөөг 125.8 хувь буюу 10,509.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 6.

/сая төгрөг/

Д/д	Орлогын төрөл	Орлого											
		2023				2024				2025			
		Төл	Гүйц	Хувь	Зөрүү	Төл	Гүйц	Хувь	Зөрүү	Төл	Гүйц	Хувь	Зөрүү
А	1	2	3	4=3/2	5=3-2	6	7	8=7/6	9=7-6	10	11	12=11/10	13=11-10
1	АТБӨЯХ-ийн татвар	470.0	692.8	147%	(222.8)	620.0	809.0	130%	(189.0)	808.0	950.1	118%	(142.1)
2	ААН-ийн татвар	4,650.0	591.9	13%	4,058.1	2,240.0	4,736.4	211%	(2,496.4)	6,560.0	7,323.3	112%	(763.3)
3	Газрын дуудлага худалдаа	700.0	752.8	108%	(52.8)	650.0	950.4	146%	(300.4)	610.0	1,854.0	304%	(1,244.0)
4	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	11,960.8	15,807.6	132%	(3,846.8)	17,097.3	22,087.7	129%	(4,990.4)	23,883.1	27,792.4	116%	(3,909.3)
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,000.0)	(752.1)	75%	(247.9)	(1,009.0)	(1,009.0)	100%	(0.0)	(1,418.0)	(1,418.0)	100%	-
6	Үйл ажиллагааны орлого	461.0	456.9	99%	4.1	2,460.1	3,927.9	160%	(1,467.8)	1,718.0	2,034.0	118%	(316.0)
7	Хөрөнгийн орлого /хад.хүү.ор/	1,036.0	1,207.1	117%	(171.1)	1,092.0	1,708.1	156%	(616.1)	1,616.2	1,923.6	119%	(307.4)

8	Хөрөнгө борлуулсны орлого	277.4	286.7	103%	(9.3)	302.2	473.3	157%	(171.1)	417.8	550.9	132%	(133.1)
9	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал		0.5		(0.5)	1.0	2.3	235%	(1.3)	3.6	4.3	119%	(0.7)
10	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	620.5	747.9	121%	(127.4)	692.4	1,019.3	147%	(326.9)	929.2	1,279.6	138%	(350.4)
11	Галт эзвэгийн албан татвар	47.2	47.1	100%	0.0	36.5	38.9	107%	(2.4)	36.1	40.1	111%	(4.0)
12	Малд ногдуулах албан татвар	1,460.3	1,199.7	82%	260.6	721.1	888.1	123%	(167.0)	568.0	831.1	146%	(263.1)
13	Улсын тэмдэгийн хураамж	243.1	358.7	148%	(115.6)	267.7	547.8	205%	(280.1)	326.3	629.4	193%	(303.1)
14	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	75.1	64.1	85%	11.0	74.4	79.7	107%	(5.3)	70.7	64.1	91%	6.6
15	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	653.4	781.7	120%	(128.3)	791.4	908.8	115%	(117.4)	886.7	963.2	109%	(76.5)
16	Газрын төлбөр	973.5	1,105.1	114%	(131.6)	1,330.0	1,431.5	108%	(101.5)	1,233.4	1,357.6	110%	(124.2)
17	Ойн нөөц ашигласны төлбөр	319.7	1,146.6	359%	(826.9)	320.0	1,136.8	355%	(816.8)	536.3	1,367.1	255%	(830.8)
18	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	572.4	1,266.4	221%	(694.0)	566.0	1,288.0	228%	(722.0)	554.3	1,178.9	213%	(624.6)
19	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	923.0	1,058.6	115%	(135.6)	1,107.0	1,725.5	156%	(618.5)	1,420.1	2,543.4	179%	(1,123.3)
	<b>Татварын орлогын дүн</b>	<b>24,443.4</b>	<b>26,820.1</b>	<b>110%</b>	<b>(2,376.7)</b>	<b>29,360.1</b>	<b>42,750.4</b>	<b>146%</b>	<b>(13,390.3)</b>	<b>40,759.8</b>	<b>51,269.1</b>	<b>126%</b>	<b>(10,509.3)</b>

Татварын орлогын гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр авч үзвэл татварын орлого 110-146 хувиар буюу 2,376.7-13,390.3 сая төгрөгөөр давж биелсэн байгаа нь орлогын нөөц байгааг харуулж байна.

Татварын орлого давж биелэхэд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 3,909.3 сая төгрөг, аж ахуй нэгжийн татварын орлого 763.3 сая төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 1,244.0 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 830.8 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 624.6 сая төгрөг, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 1,123.3 сая төгрөгөөр тус тус давсан нь нөлөөлсөн байна.

- ✓ Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын татварыг 23,883.1 сая төгрөгөөр төлөвлөж, 3,909.3 сая төгрөгөөр давж биелэн 27,792.4 сая төгрөг төсөвт төвлөрсөн нь 2024 онд Засгийн газрын 238 дугаар тогтоолоор "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн" тогтоосон мөн Эрдэнэс критикал мениралс ТӨҮГ өмнөх оны өр барагдсантай холбоотой байна.
- ✓ Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 536.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,367.1 сая төгрөг төвлөрүүлж, 830.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь Өмнөдэлгэр, Батширээт сумдад самрын дуудлага худалдааны орлого орсонтой холбоотой байна. Тус орлого нь 2023 онд 826.9 сая, 2024 онд 816.9 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.
- ✓ Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 566.0 сая төгрөгөөр төлөвлөж, 722.0 сая төгрөгөөр давуулан биелүүлж 1,288.0 сая төгрөг төвлөрүүлсэн нь Галшар, Баянмөнх, Баянхутаг, Жаргалтхаан, Баян-Адарга, Баян-Овоо, Мөрөн сумдад шонхор барих, Дэлгэрхаан суманд угалз, Батширээт суманд халиун буга, агнуурын шувуу агнах зөвшөөрөл олгосонтой холбоотой байна.

## Орлогын гүйцэтгэлийн сумдаар

Хүснэгт 7.

/сая төгрөг/

№	Сумын нэр	2024				2025			
		Төл	Гүйц	Зөрүү	Биелэлт	Төл	Гүйц	Зөрүү	Биелэлт
		1	2	3=2-1	4=2/1	5	6	7=6-5	8=6/4
1	Галшар	357.8	578.6	220.8	162%	430.1	553.5	123.4	129%
2	Баянхутаг	309.0	453.9	144.9	147%	367.4	495.3	127.8	135%
3	Баянмөнх	353.5	662.8	309.3	187%	422.2	501.0	78.8	119%
4	Дархан	708.8	947.3	238.5	134%	830.1	1,034.7	204.6	125%
5	Дэлгэрхаан	560.7	919.2	358.5	164%	873.1	990.7	117.6	113%
6	Жаргалтхаан	766.4	716.9	(49.5)	94%	620.1	744.8	124.7	120%
7	Цэнхэрмандал	1,042.4	861.2	(181.3)	83%	730.7	749.2	18.5	103%
8	Өмнөдэлгэр	937.6	1,414.8	477.2	151%	988.1	1,467.8	479.8	149%
9	Батширээт	555.3	1,111.3	556.0	200%	863.5	1,378.6	515.1	160%
10	Биндэр	647.6	975.9	328.3	151%	833.0	968.8	135.8	116%
11	Баян-Адарга	455.2	609.3	154.1	134%	514.1	554.5	40.3	108%
12	Дадал	959.2	1,342.4	383.2	140%	1,318.7	1,403.7	85.1	106%
13	Норовлин	521.5	785.8	264.3	151%	680.3	808.2	128.0	119%
14	Батноров	655.4	1,028.7	373.3	157%	792.5	1,038.2	245.7	131%
15	Баян-овоо	542.9	753.3	210.4	139%	559.6	729.4	169.7	130%
16	Мөрөн	361.7	588.8	227.1	163%	467.9	617.8	149.9	132%
17	Хэрлэн	11,505.9	19,980.7	8,474.8	174%	19,626.4	24,731.4	5,104.9	126%
18	Гурванбаян	181.7	225.2	43.5	124%	251.2	253.5	2.3	101%
19	Хэрлэнбаян-Улаан	107.6	128.6	21.0	120%	133.8	156.6	22.8	117%
20	Өлзийт	113.3	261.8	148.5	231%	267.0	659.2	392.3	247%
21	Бор-Өндөр	7,262.4	7,769.6	507.2	107%	8,557.0	10,705.1	2,148.1	125%
22	Бэрх	454.2	634.2	180.0	140%	633.0	727.0	94.1	115%
24	<b>Нийт</b>	<b>29,360.1</b>	<b>42,750.4</b>	<b>13,390.3</b>	<b>145.6</b>	<b>40,759.8</b>	<b>51,269.1</b>	<b>10,509.3</b>	<b>125.8</b>

Дээрх хүснэгтээс харвал орлогын төлөвлөгөө 101 – 247 хувийн биелэлттэй байна. Энэ нь төсвийн орлогын нөөцийг бүрэн тооцож төлөвлөхгүй байгааг харуулж байна. Орлогын төлөвлөгөөг Хэрлэн сум 5,104.9 сая төгрөгөөр, Бор-Өндөр сум 2,148.1 сая төгрөгөөр давуулж биелүүлсэн нь хамгийн өндөр гүйцэтгэлтэй байна.

**Санхүүгийн дэмжлэг:**

Хэнтий аймгийн 2025 оны төсвийг батлахдаа улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгт 38,777.6 сая төгрөг төлөвлөснөөс, тодотголоор 13,543.6 сая төгрөгөөр бууруулан 23,761.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр бүрэн олгосон байна.

**Орлогын шилжүүлэг:**

ОНХС-ийн сангийн орлогын шилжүүлэгт 23,761.1 сая төгрөг батлагдсанаас тодотголоор 7,526.9 мянган төгрөгийг бууруулж 16,234.2 сая төгрөг олгохоор төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 156.6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу шилжүүлж, 16,077.6 сая төгрөгийг олгосон байна. Орлогын шилжүүлгийг сумдад 9,069.2 сая төгрөгийг олгож, аймгийн ОНХС-д 7,008.4 сая төгрөгийг тус тус олгосон байна.

**Сумаас аймагт төвлөрүүлэх орлого:**

Төсвийн тодотголоор сумын төсвөөс аймагт төвлөрүүлэх орлогын хэмжээг 9,060.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.

**Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх  
орлогын төлөвлөгөө гүйцэтгэл.**

Хүснэгт 8.

/сая төгрөг/

Д/д	Сумдын нэр	Төлөвлөгөө		Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
		Анх баталсан	Тодотгосон			
1	Бор -Өндөр	3,777.5	4,705.8	4,705.8	-	100%
2	Хэрлэн	2,580.1	4,354.3	4,354.3	-	100%
	<b>ДҮН</b>	<b>6,357.6</b>	<b>9,060.1</b>	<b>9,060.1</b>	<b>-</b>	<b>100%</b>

Татварын орлогын гүйцэтгэлийн авч үзвэл Бор-Өндөр сум 2,148.8 сая төгрөгөөр, Хэрлэн сум 5,104.9 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна.

Татварын бус орлогоор 2025 онд 6,814.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 9,512.0 сая төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөөг 140 хувь буюу 2,698.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

**Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

Хүснэгт 9.

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын бус орлого</b>	<b>6,814.0</b>	<b>9,512.0</b>	<b>2,698.0</b>	<b>140%</b>
Нийтлэг татварын бус орлого	6,614.0	9,256.8	2,642.8	140%
Торгуулийн орлого	3,163.0	5,455.3	2,292.2	172%
Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,132.9	1,198.6	65.7	106%
Төсөвт байгууллагын өөрийн орлого /тусгах/	1,390.1	1,361.8	(28.3)	98%
Бусад орлого	928.0	1,241.2	313.2	134%
Хөрөнгийн орлого	200.0	255.2	55.2	128%
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	200.0	255.2	55.2	128%

**Үндсэн үйл ажиллагааны орлогод 1,217.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.**

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2025 онд үндсэн үйл ажиллагааны орлогод хоршоо хөгжүүлэх сангийн орлогын эргэн төлөлтөөс 1,132.9 сая төгрөг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,197.3 сая төгрөгийг төвлөрүүлж, 64.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

**Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн  
орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

Хүснэгт 10.

/сая төгрөг/

№	Байгууллага	Баталсан	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Хэ. Дархан.	51.6	29.2	(22.4)	57%
2	Хэ. Дэлгэрхаан.	75.0	11.4	(63.6)	15%
3	Хэ. Баянхутаг.	43.0	13.5	(29.5)	31%
4	Хэ. Баянмөнх.	15.0	16.0	1.0	106%
5	Хэ. Галшар.	10.0	8.4	(1.6)	84%
6	Хэ. Жаргалтхаан.	65.9	77.3	11.4	117%
7	Хэ. Баян-Овоо.	30.0	19.1	(10.9)	64%
8	Хэ. Мөрөн.	32.5	31.8	(0.7)	98%
9	Хэ. Норовлин.	20.0	51.9	31.9	260%
10	Хэ. Батширээт.	41.0	54.9	13.9	134%
11	Хэ. Хэрлэн.	275.0	145.1	(129.9)	53%
12	Хэ. Бэрх.	14.0	10.4	(3.6)	74%
13	Хэ. Цэнхэрмандал.	20.0	76.7	56.7	383%
14	Хэ. Өмнөдэлгэр.	12.6	46.2	33.6	367%
15	Хэ. Батноров.	50.0	50.7	0.7	101%
16	Хэ. Баян-Адарга.	30.0	125.2	95.2	417%
17	Хэ. Дадал	99.1	155.4	56.4	157%
18	Хэ. Биндэр	-	44.7	44.7	
19	Хэ. Бор-Өндөр	238.4	228.3	(10.0)	96%
20	Хэ. Хэрлэн баян Улаан	9.9	1.0	(8.9)	10%
	<b>Хоршоо хөгжүүлэх сангийн дүн</b>	<b>1,132.9</b>	<b>1,197.3</b>	<b>64.4</b>	<b>106%</b>

Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар нь авч үзвэл:

- Баянмөнх, Жаргалтхаан, Норовлин, Батширээт, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Батноров, Баян-Адарга, Дадал зэрэг 9 сум 100-383 хувь буюу 300.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бол
- Дархан, Дэлгэрхаан, Баянхутаг, Галшар, Бэрх, Хэрлэнбаян-Улаан, Баян-Овоо, Мөрөн, Хэрлэн, Бор-Өндөр зэрэг 10 сумын биелэлт 10-98 хувь буюу 281.0 сая төгрөгөөр тасарсан байна. Үүнээс Дэлгэрхаан, Баянхутаг сум, ХБУ тосгоны орлого хангалтгүй буюу 10-30 хувийн биелэлттэй байна.
- Биндэр сумын ХХС нь орлогын төлөвлөгөө огт батлаагүй ба гүйцэтгэлээр 44.7 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн орлогыг огт төлөвлөөгүй, биелэлт хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

### Туслах үйл ажиллагааны орлого:

Туслах үйл ажиллагааны орлогоор 1,398.6 сая төгрөгийн төсөв бүрдүүлэхээр батлагдсанаас төсөвт байгууллага, ОНӨААТҮГ-ууд 321.2 сая төгрөг, ОНХС-ийн орлого 1,023.5 сая төгрөг, БХС-ийн орлого 109.6 сая төгрөг, малыг эрсдэлээс хамгаалах сангийн орлого 17.1 сая төгрөг, нийт 1,471.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 105 хувь буюу 72.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

### Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 11.

/сая төгрөг/

№	Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	№	Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Дархан.	50.0	110.5	60.5	221%	15	Батноров.	1.0	44.3	43.3	4415%
2	Дэлгэрхаан.	2.5	4.0	1.5	160%	16	Баян-Адарга.	8.3	34.3	26.0	115%
3	Баянхутаг.	0.5	1.1	0.6	50%	17	Дадал.				
4	Баянмөнх.					18	Биндэр.	18.0	7.0	(11.0)	39%
5	Галшар.	2.0	2.0	-	100%	19	Бор-Өндөр	180.0	182.0	2.0	100%
6	Жаргалтхаан.	-	0.4	0.4	0%	20	Хэрлэн баян Улаан				
7	Баян-Овоо.	-	3.6	3.6	0%	21	Гурванбаян	0.6	0.5	(0.1)	70%
8	Мөрөн.	-	0.7	0.7	0%	22	Тахилгат	-	0.4	0.4	0%
9	Норовлин.	-	0.1	0.1	0%		<b>Сумдын дүн</b>	<b>323.1</b>	<b>487.0</b>	<b>164.0</b>	<b>6799%</b>
10	Батширээт.	10.0	10.5	0.5	105%	23	Засаг дарга	-	35.6	35.6	0%
11	Хэрлэн.	-	20.83	20.83		24	Засаг даргын тамгын газар	15.0	18.7	3.7	124%
12	Бэрх.					25	Орон нутгийн хөгжлийн сан	1,060.5	913.0	(147.5)	86%
13	Цэнхэрмандал	5.0	11.8	6.8	236%	26	Мал хамгаалах сан	-	17.1	17.1	0%
14	Өмнөдэлгэр.	45.2	53.0	7.9	1186%		<b>Аймгийн дүн</b>	<b>1,075.5</b>	<b>984.4</b>	<b>(91.1)</b>	<b>211%</b>
<b>НИЙТ ДҮН</b>								<b>1,398.6</b>	<b>1,471.4</b>	<b>72.8</b>	<b>105%</b>

Туслах үйл ажиллагааны орлогын 33.1 хувь буюу 487.0 сая төгрөгийг сумдаас, 66.9 хувь буюу 984.4 сая төгрөгийг аймгаас бүрдүүлжээ. Томоохон өөрчлөлтийн авч үзвэл:

- Аймгийн засаг даргын ангилагдаагүй бусад зардал дансанд орсон өмнөх оны төрийн албаны шалгалтад бэлтгэх сургалтын төлбөрийн авлага, засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгосон зээлийн эргэн төлөлт зэрэг нийт 35.6 сая төгрөг,
- Малыг эрсдэлээс хамгаалах санд орсон өвсний үнэ 17.1 сая төгрөг,
- аймгийн ОНХС-д орсон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 60 аж ахуйн нэгжээс нийгмийн хариуцлагын гэрээний дагуу 913.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Баянмөнх, Бэрх, Хэрлэнбаян-Улаан, Тахилгат, Дадал сум нь туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй байна.

Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нэгтгэгддэг ТТЗ болон ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой нийт 779.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 770.7 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж, 9.1 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоосон байна. Үүнд:

1. Баян-Овоо, Гурванбаян, Дадал, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сум нь малын тоо толгойн албан татварын орлогын 9.1 сая төгрөгийг ОНХС-д дутуу төвлөрүүлсэн;

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоосон.

2. Батноров сум 12.1 сая төгрөг, Батширээт сум 8.4 сая төгрөг, Баян -Адарга сум 1.1 сая төгрөг, Баянхутаг сум 29.2 сая төгрөг, Бор-Өндөр сум 123.0 сая төгрөг, Галшар сум 13.2 сая төгрөг, Гурванбаян тосгон 12.8 сая төгрөг, Дадал сум 36.9 сая төгрөг, Дархан сум 24.6 сая өгрөг, Дэлгэрхаан сум 102.9 сая төгрөг, Жаргалтхаан сум 43.4 сая төгрөг, Норовлин сум 13.0 сая төгрөг, Хэрлэн сум 265.4 сая төгрөг, Цэнхэрмандал сум 84.5 сая төгрөг, нийт 770.7 сая төгрөгийн орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь бүрдүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөвлөмж хүргүүлсэн.

**БҮЛЭГ 2. ТӨСВӨӨС 2,117.4 САЯ ТӨГРӨГ БУЮУ НИЙТ ЗАРДЛЫН 2 ХУВИЙГ ХУУЛЬ, ТОГТООМЖ ЗӨРЧИЖ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

**Харьяа байгууллагууд 453.1 сая төгрөгийг зориулалт бусаар, 282.1 сая төгрөгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй, 1,382.2 сая төгрөгийг хууль тогтоомжийг зөрчиж зарцуулсан байна.**

**Аймгаас сумдад олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийг бүрэн олгосон байна.**

Аймгийн ИТХ-ын 2025 оны 7 дугаар сарын 29-ний долоо дугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор 2025 оны төсвийн жилд аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 21,951.3 сая төгрөг, аймгийн ОНХС-аас сумын орон нутгийн санд олгох орлогын шилжүүлэг 9,069.2 сая төгрөг олгохоор баталсан байна.

Гүйцэтгэлээр сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг хуваарийн дагуу бүрэн олгож, аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 156.6 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

**Төсвийн нийт зарлагыг 118,188.4 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 102,015.9 сая төгрөгийг зарцуулсан байна.**

Хэнтий аймгийн 2025 оны төсвийн тодотголоор нийт зарлагыг 118,188.4 сая төгрөгөөр баталснаас 102,015.9 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 86.3 хувь буюу 16,172.6 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

Төсвийн гүйцэтгэл, хөтөлбөр арга хэмжээний ангиллаар

Хүснэгт 12.

/сая төгрөг/

№	Хөтөлбөрийн нэр	2025				
		Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	хувь	Дүнд эзлэх хувь
	Нийт зардлын дүн	118,188.4	102,015.9	16,172.6	86.3	100.0

1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	6,743.3	5,876.8	866.5	87.2	5.8
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	57,423.2	49,502.8	7,920.4	86.2	48.5
3	Худалдан авах ажиллагаа	308.3	245.6	62.7	79.7	0.2
4	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	441.1	347.9	93.2	78.9	0.3
5	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	549.7	448.3	101.4	81.6	0.4
6	Орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг	21,420.6	16,405.3	5,015.3	76.6	16.1
7	Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого	793.1	793.1	-	100.0	0.8
8	Мал аж ахуйг хөгжүүлэх	1,390.9	1,351.5	39.4	97.2	1.3
9	Авто зам	15.0	2.0	13.0	13.4	0.0
10	Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр	877.1	768.9	108.2	87.7	0.8
11	Ойжуулалт	9.0	-	9.0	-	-
12	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	2,413.7	2,204.1	209.6	91.3	2.2
13	Хот байгуулалт, тохижилт	4,930.8	4,919.0	11.8	99.8	4.8
14	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	3,620.1	3,311.7	308.5	91.5	3.2
15	Биеийн тамир спорт	387.6	345.8	41.8	89.2	0.3
16	Соёл урлаг	2,805.8	2,589.2	216.5	92.3	2.5
17	Сургуулийн өмнөх боловсрол	3,466.8	3,104.7	362.1	89.6	3.0
18	Ерөнхий боловсрол	9,292.7	8,571.9	720.7	92.2	8.4
19	Мэргэжлийн боловсрол	917.3	904.1	13.2	98.6	0.9
20	Насан туршийн боловсрол	12.9	10.2	2.7	78.8	0.0
21	Нийгмийн халамж	179.6	134.4	45.2	74.8	0.1
22	Хүүхдийн хөгжил, хамгаалал	50.0	41.7	8.3	83.3	0.0
23	Ахмад настны хөгжил хамгаалал	139.9	136.9	3.0	97.8	0.1

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг хөтөлбөрөөр нь авч үзвэл орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 48.5 хувь, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг 16.1 хувь, ерөнхий боловсрол 8.4 хувь, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа 5.8 хувь, бусад 18 хөтөлбөр 21.2 хувийг тус тус эзэлж байна.

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл өмнөх оноос 8,106.6 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд урсгал зардал 7,327.7 сая төгрөг, эргэж төлөгдөх зээлийн зардал 1,345.3 сая төгрөгөөр өсөж, хөрөнгийн зардал 566.4 сая төгрөгөөр буурсан байна.

### Төсвийн зарлагын гүйцэтгэл, эдийн засгийн ангиллаар

Хүснэгт 13.

Үзүүлэлт	/сая төгрөг/					
	Өмнөх оны гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Гүйцэтгэлийн зөрүү
А	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>93,909.30</b>	<b>118,188.4</b>	<b>102,015.9</b>	<b>16,172.6</b>	<b>86.3</b>	<b>8,106.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>65,807.20</b>	<b>81,168.6</b>	<b>73,134.9</b>	<b>8,033.7</b>	<b>90.1</b>	<b>7,327.7</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>63,117.60</b>	<b>79,601.4</b>	<b>71,834.2</b>	<b>7,767.2</b>	<b>90.2</b>	<b>8,716.6</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,064.00	27,542.8	25,787.5	1,755.3	93.6	4,723.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,569.80	3,444.5	3,155.7	288.7	91.6	585.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,393.50	22,237.5	20,000.7	2,236.8	89.9	1,607.2
Хангамж, бараа материалын зардал	1,394.70	1,569.9	1,235.3	334.7	78.7	-159.4
Нормативт зардал	743.2	99.5	57.4	42.1	57.7	-685.8
Эд хогшил, урсгал засварын зардал	2,845.70	3,251.0	2,889.9	361.1	88.9	44.2

Томилолт, зочны зардал	676.8	890.6	717.5	173.1	80.6	40.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,704.90	13,137.6	11,762.0	1,375.6	89.5	3,057.1
Бараа үйлчилгээний бусад зардал	6,724.90	7,428.0	6,228.2	1,199.8	83.8	-496.7
<b>ТАТААС</b>	<b>399.0</b>	<b>15.0</b>	<b>2.0</b>	<b>13.0</b>	<b>13.4</b>	<b>-397.0</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	8.0	15.0	2.0	13.0	13.4	-6.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	391.0	0.0	0.0	0.0		-391.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,290.60</b>	<b>1,552.2</b>	<b>1,298.7</b>	<b>253.5</b>	<b>83.7</b>	<b>-991.9</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	225.2	278.0	270.6	7.4	97.3	45.4
Бусад урсгал шилжүүлэг	2,065.40	1,274.2	1,028.1	246.1	80.7	-1,037.3
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,029.70</b>	<b>32,463.8</b>	<b>26,463.3</b>	<b>6,000.5</b>	<b>81.5</b>	<b>-566.4</b>
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>1,072.40</b>	<b>4,556.1</b>	<b>2,417.7</b>	<b>2,138.4</b>	<b>53.1</b>	<b>1,345.3</b>

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 102,015.9 сая төгрөгийн 71.7 хувь буюу 73,134.9 сая төгрөгийг урсгал зардал, 25.9 хувь буюу 26,463.3 сая төгрөгийг хөрөнгийн зардал, 2.4 хувь буюу 2,417.7 сая төгрөгийг эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл эзэлж байна.

Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 16,172.6 сая төгрөгийн 49.7 хувийг урсгал зардал, 37.1 хувийг хөрөнгийн зардал, 13.2 хувийг эргэн төлөгдөх зээлийн зардал эзэлж байна. Үүнд:

- ✓ Урсгал зардлын зарцуулаагүй 8,033.7 сая төгрөгийн үлдэгдэлд цалингийн зардал 21.8 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 27.4 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 17.1 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 14.9 хувийг тус тус эзэлж байна.
- ✓ Хөрөнгийн зардлаас зарцуулаагүй 6,000.5 сая төгрөгийн үлдэгдэлд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалт 83.6 хувь, аймгийн хөрөнгө оруулалт 10.2 хувь, сумдын ЗДТГ-ын хөрөнгө оруулалт 6.2 хувийг эзэлж байна.
- ✓ Эргэн төлөгдөх зээлийн зардалд төлөвлөсөн 2,138.4 сая төгрөгийг олгоогүй байгаа нь Хоршоог хөгжүүлэх сангийн журмын шаардлагад нийцсэн зээлдэгчийн материал ирээгүйтэй холбоотой байна.

### **Орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар батлагдсан орон тоо 751, гүйцэтгэл 745 байна.

#### Батлагдсан орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 14.

Байгууллага	НТГ-ийн тайлан		Аудитаар гүйцэтгэл			
	Төл	Гүйц	Төл	Гүйц	Дутуу	Илүү
Сумын ЗДТГ	508	417	508	512	95	
Сумын ИТХ	57	41	57	56	15	
Аймгийн ИТХ	14	13	14	13		
Аймгийн ЗДТГ	80	80	80	80		
Хэ. Санхүүгийн хяналт, аудитын алба	10		10	8	8	
Хэ. Байгаль орчны алба	50	46	50	46		
Хэ. Орон нутгийн өмчийн газар	8	10	8	10		
Хэ. Худалдан авах ажиллагааны газар .	7	3	7	3		
Ой ангиуд	17	13	17	17	4	

Хэ. Бор-Өндөр. Цэцэрлэг /Нархан/		21				21
Хэ. Баянмөнх. Хүн эмнэлэг		19				19
Хэ. Цэнхэрмандал. Соёлын төв		7.5				7.5
<b>Нийт дүн</b>	<b>751</b>	<b>670.5</b>	<b>751</b>	<b>745</b>	<b>122</b>	<b>47.5</b>

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайланд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, Батширээт сумын ЗДТГ, Батширээт ой анги, Норовлин сумын ЗДТГ, Баян-Овоо сумын ИТХ, Дадал сумын ИТХ, ЗДТГ, Мөрөн сумын ИТХ, ЗДТГ, Хэрлэн сумын ИТХ зэрэг 10 байгууллага 122 орон тооны гүйцэтгэлийг тайлагнаагүй, улсын төсвийн 3 байгууллага 47.5 орон тоог илүү тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой 2,117.4 сая төгрөгийн дараах зөрчил илэрснээс 53.7 сая төгрөгийн зөрчилд 18 төлбөрийн акт, 2,058.9 сая төгрөгийн зөрчилд 61 албан шаардлага, 4.8 сая төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

1. Батширээт, Батноров, Баян-Адарга, Баян-Овоо, Баянмөнх, Биндэр, Бор-Өндөр, дадал, Жаргалтхаан, Норовлин, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумдын ЗДТГ, Бэрх, Гурванбаян тосгоны ЗАА, Галшар сумын ОНХС нь нийт 453.1 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд 32 албан шаардлага хүргүүлсэн.
2. Аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ, Батширээт, Баян-Овоо, Баянмөнх, Галшар, Дадал, Дархан, Жаргалтхаан, Норовлин, Баян-Адарга, Хэрлэн сумдын ЗДТГ, Дадал, Жаргалтхаан, Хэрлэн, Цэнхэрмандал, Норовлин сумдын ИТХ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, Байгаль орчны газар, Цэнхэрмандал сумын ОНХС нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан 250.6 сая төгрөгийн зөрчилд 51.6 сая төгрөгийн 17 төлбөрийн акт, 230.4 сая төгрөгийн 14 албан шаардлага хүргүүлсэн.
3. Холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн 1,382.2 сая төгрөгийн зөрчилд 2.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,375.3 сая төгрөгийн 15 албан шаардлага, өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 4.8 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:
  - Баянмөнх, Цэнхэрмандал сумын ЗДТГ, Өлзийт тосгоны ЗАА санхүүгийн албаны сул орон тоог Тамгын газрын нягтлан бодогчид түр хавсруулан гүйцэтгүүлсэн, Тахилгат, Өлзийт тосгоны ЗАА хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтний орон тоонд Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан тусгай шалгалт өгөөгүй, нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилон ажиллуулсан нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 26 дугаар зүйлийн 26.1, 43 дугаар зүйлийн 43.6-т заасныг зөрчсөн.
  - Хэрлэн сумын ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид нэмэгдэл цалин, үр дүнгийн урамшуулалд 38,851.6 олгосон нь Төрийн албаны тухай хууль, Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2.3-т заасныг тус тус зөрчсөн, ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөртөө шийдвэр гаргаж 2,066.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс авсан, Өндөрхаан хот тохижилт төрийн алба хаасны нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдэлд 221.9 сая төгрөгийг олгосон.
  - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас Батширээт сумын ЗДТГ он дамжин хэрэгжсэн 47.9 сая төгрөгийн 4 арга хэмжээг бүрэн дуусгаагүй, гэрээг дүгнээгүй, тооцоог хийгээгүй, Баян-Овоо сумын ЗДТГ 40.0 сая төгрөгийн өртөг бүхий тарвага сэргээн нутагшуулах ажлыг 20.0 сая төгрөгийн 2 багц болгон шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн.

- Өмнөдэлгэр сумын Засаг дарга сумын ИТХ-аар төсөв нь батлагдаагүй 21.4 сая төгрөгийн 3 арга хэмжээг хэрэгжүүлсэн, Галшар сумын ОНХС магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөвгүй 539.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулсан, Дэлгэрхаан сумын ОНХС гэрээ зөрчин 29.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр, Цэнхэрмандал сумын ОНХС гэрээ байгуулаагүй, хүлээн аваагүй 2 арга хэмжээнд 35.2 сая төгрөг, Цэнхэрмандал сумын ОНХС журам зөрчин 22 төсөл арга хэмжээнд 30-аас дээш хувиар 353.5 сая төгрөгийн, Гурванбаян тосгоны Захирагч 3 төсөл арга хэмжээнд 30-аас дээш хувиар 24.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон, нийт 1,003.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- Жаргалтхаан сумын ЗДТГ төвийн халаалтын шугамд холбогдон дулаан нийлүүлэх гэрээний дагуу халаалтын төлбөр төлдөг ч нэмэлтээр нүүрс худалдан авахад 4.8 сая төгрөг зарцуулж төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулж өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой 393.6 сая төгрөгийн дараах 9 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд Биндэр сумын ЗДТГ 17.6 сая төгрөг, Галшар сумын ЗДТГ 221.5 сая төгрөг, Өлзийт тосгоны ЗАА 0.8 сая төгрөг, Баянхутаг сумын ИТХ 10.5 сая төгрөг, Жаргалтхаан сумын ИТХ 8.0 сая төгрөг, ОНӨГ 112.3 сая төгрөг, Бор-Өндөр сумын ОНХС 10.0 сая төгрөг, Мөрөн сумын ХХС 3.0 сая төгрөг, Хэнтий шинэс сум дундын ой анги 8.9 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг тус тус тохируулаагүй алдаа илэрснийг залруулсан.

#### **Төсвийн санхүүжилттэй холбоотой илрүүлэлт:**

Батлагдсан санхүүжилтийг Өмнөдэлгэр ой анги ОНӨҮГ-т 5.4 сая төгрөг, Батширээт ой анги ОНӨҮГ-т 3.5 сая төгрөгөөр илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8 “ төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох” гэж заасныг зөрчсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар санхүүжилттэй холбоотой 107.2 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэнд 4 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

- Батширээт сумын Засаг дарга санхүүжилтийг ЗДТГ-т 25.2 сая төгрөгөөр,
- Дадал сумын Засаг дарга санхүүжилтийг ЗДТГ-т 63.6 сая төгрөгөөр,
- Цэнхэрмандал сумын Засаг дарга санхүүжилтийг ИТХ, Эрүүл мэндийн төвд 1.0 сая төгрөгөөр батлагдсан төсвөөс тус тус илүү олгосон,
- Дархан сумын Засаг дарга сумын ИТХ-аар баталсан тогтмол зардлын санхүүжилтийг Соёлын төвд 4.8 сая төгрөг, Цэцэрлэгт 3.9 сая төгрөгөөр дутуу, ЕБС-д 8.7 сая төгрөгөөр илүү олгосон байна.

**Нэмэлт санхүүжилтийн данснаас 2,737.1 сая төгрөгийг зарцуулж, 426.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.**

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд 3,163.4 сая төгрөгийн орлого төвлөрч, 2,737.1 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 426.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн орлого дараах эх үүсвэрүүдээс бүрдсэн байна. Үүнд:

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 11.0 сая төгрөг, 0.3 хувь
- ✓ ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 73.0 сая төгрөг, 2.3 хувь
- ✓ Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 471.5 сая төгрөг, 14.9 хувь
- ✓ Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 2,607.9 сая төгрөг, 82.4 хувь байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны нийт орлогын 23.2 хувийг аймаг, сумын ЗДТГ, 12.2 хувийг Батширээт ой анги, 2.5 хувийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар, 2.4 хувийг Бор-Өндөр хот тохижилтын газар, 1.7 хувийг аймаг, сумын ИТХ, 1.6 хувийг Хэрлэн сумын хот тохижилтын газар, 0.1 хувийг ОНӨГ, 0.1 хувийг ХААГ бүрдүүлсэн байна.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого өмнөх оноос 2,979.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх аудитаар аймаг, сумын ЗДТГ-ын байнгын шинжтэй, төлөвлөх боломжтой орлогыг нэмэлт дансанд төвлөрүүлэхгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

## Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Хүснэгт 16

/ сая төгрөг /

Үзүүлэлт	2024 оны гүйц	2025 оны гүйц	Бууралт		Нийт зардалд эзлэх хувь
			Зөрүү	Хувь	
<b>II НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,445.2</b>	<b>2,737.1</b>	<b>4,708.1</b>	<b>36.8</b>	<b>100.0</b>
<b>21 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,820.5</b>	<b>2,693.7</b>	<b>4,126.8</b>	<b>39.5</b>	<b>98.4</b>
<b>210 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,037.8</b>	<b>2,678.2</b>	<b>3,359.6</b>	<b>44.4</b>	<b>97.8</b>
2101 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44.8	51.5	- 6.7	114.9	1.9
2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4.5	5.9	- 1.4	129.8	0.2
2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24.4	6.1	18.3	25.0	0.2
2104 Хангамж, бараа материалын зардал	106.0	135.8	- 29.8	128.2	5.0
2105 Нормативт зардал	6.9	0.8	6.1	11.6	0.6
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	164.3	147.2	17.1	89.6	5.4
2107 Томилт, зочны зардал	45.9	38.3	7.6	83.5	1.4
2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	423.6	382.2	41.4	90.2	14.0
2109 Бараа үйлчилгээний бусад зардал	5,217.4	1,910.5	3,306.9	36.6	69.8
<b>213 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>782.7</b>	<b>15.5</b>	<b>767.2</b>	<b>2.0</b>	<b>0.6</b>
213209 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40.0	15.5	24.5	38.7	0.6
<b>2133 Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>742.7</b>	<b>426.3</b>	<b>316.4</b>	<b>57.4</b>	<b>15.6</b>
213405 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	742.7	426.3	316.4	57.4	15.6
<b>22 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>624.7</b>	<b>43.4</b>	<b>581.3</b>	<b>6.9</b>	<b>1.6</b>
<b>I ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>7,233.7</b>	<b>3,163.4</b>	<b>4,070.3</b>	<b>43.7</b>	<b>100.0</b>
131101 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3.0	11.0	- 8.0	366.7	0.3
131103 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11.9	73.0	- 61.1	613.4	2.3
131104 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,631.0	471.5	1,159.5	28.9	14.9

131105 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,587.8	2,607.9	2,979.9	46.7	<b>82.4</b>
9 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	211.4	-	211.4		
10 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-			
I ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,233.7	3,163.4	4,070.3	43.7	<b>100.0</b>

Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 426.3 сая төгрөгийг 43 байгууллага төсөвт төвлөрүүлснээс 33 байгууллага нь 248.7 сая төгрөгийг авлагаар тусгаж тайлагнасан байна.

*Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар Баянхутаг сумын ИТХ төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 1.0 сая төгрөгөөр илүү тайлагнасныг аудитын явцад залруулсан.*

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 91 хувь, ОНХС-ийн гүйцэтгэл 76.6 хувьтай байна.**

**Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшнийг ИТХ-аас “Үр дүнтэй” гэж үнэлсэн байна.**

Хэнтий аймгийн ИТХ-аар тайлан онд Ангилагдаагүй бусад зардал дансанд 5,787.9 сая төгрөгийн 7 чиглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлж хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны ангиллыг авч үзвэл: Эрсдэлийн сан 599.1 сая, нийтийн тээвэрт олгох татаас 17.7 сая, засаг даргын үйл ажиллагааны зардал 3,300.0 сая, дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөр 1,000.0 сая, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардал 793.1 сая, хог хаягдлын үйлчилгээний хөлс 28.0 сая, түр хамгаалах байрны зардалд 50.0 сая төгрөгийг тус тус төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр ангилагдаагүй зардалд 5,785.2 сая төгрөгийн санхүүжилт олгож үндсэн үйл ажиллагааны орлого 35.6 сая төгрөгийг бүрдүүлж, 4,087.2 сая төгрөгийг зарцуулж 733.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Зарцуулалтыг зардлын ангиллаар авч үзвэл: бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардалд 834.8 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 3,250.3 сая, орон нутгийн өмчит байгууллагад олгох татаас 2.0 сая, эргэж төлөгдөх зээлд 1,000.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг 86.3 хувьтай тайлагнасан байна.**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 23 хөтөлбөр батлагдсанаас орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны 1 хөтөлбөрт, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 22 хөтөлбөрт хамаарах орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх 23 арга хэмжээнд 102,015.9 сая төгрөгийг зарцуулан хэрэгжилтийг 86.3 хувьтай тайлагнасан байна.

Хэнтий аймгийн ИТХ-ын 2024 оны XXIX хуралдааны 01 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг, 2024 оны гуравдугаар хуралдааны 05 дугаар тогтоолын 06 дугаар хавсралтаар 44 зорилт бүхий аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус баталсан байна.

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний 2025 оны биелэлтийг 88.3 хувь, Засаг даргын 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 96.8 хувийн биелэлттэйгээр үнэлж Монгол Улсын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хорьдугаар хуралдаанаар хэлэлцэж “үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь 91 хувьтай хэрэгжсэн байна.**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 13,968.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 9,884.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 76 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ баталсан байна. Үүнээс он дамжин хэрэгжих 14 төсөл, арга хэмжээнд 1,600.8 сая төгрөг, шинээр хэрэгжүүлэх 62 төсөл, арга хэмжээнд 8,284.2 сая төгрөгийн санхүүжилтийг баталж 540.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг Цэнхэрмандал, Жаргалтхаан, Батширээт сумын Засаг даргад хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна.

Нийт хөрөнгө оруулалтын 76 төсөл, арга хэмжээний 27 нь их засварын, 13 нь барилга байгууламжийн, 21 нь тоног төхөөрөмжийн, 9 нь зураг төсвийн, 6 нь бусад төсөл, арга хэмжээ байна.

Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй 13,113.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, тайлант онд гүйцэтгэлээр 9,885.3 сая төгрөгийн санхүүжилт олгож 12,544.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 60 төсөл, арга хэмжээ бүрэн дуусаж, 568.5 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ онд дамжин хэрэгжиж байгаа бол, 308.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

**ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгжилт 76.6 хувьтай байна.**

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-аар хэрэгжүүлэх 351 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 21,420.6 сая төгрөгийг баталсан байна. Үүнд:

- ✓ Эх үүсвэрийн 16,234.2 сая төгрөг нь ОНХС-ийн орлогын шилжүүлгээс, 3,480.8 сая төгрөг нь ОНХС-ийн эхний үлдэгдлээс, 598.0 сая төгрөг нь малын тоо толгойн албан татвар, нийгмийн хариуцлагын хүрээнд уул уурхайн компаниудаас гэрээний дагуу төвлөрүүлэх 1,060.5 сая төгрөг байна.
- ✓ Аймгийн ОНХС нь 7,293.3 сая төгрөг буюу 44.4 хувь, сумын ОНХС нь 9,112.0 сая төгрөг буюу 55.6 хувийг эзэлж байна.

ОНХС-ийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Хүснэгт 17.

/сая төгрөг/

№	Сумын нэр	Анх батлагдсан төсөвт өртөг		Тодотгосон төсөвт өртөг		2025 онд санхүүжүүлэх дүн		Гүйцэтгэл		Хэрэгжилт /Хувь/
		Арга хэмжээ	Дүн	Арга хэмжээ	Дүн	Арга хэмжээ	Дүн	Арга хэмжээ	Дүн	
1	Аймаг	43	20,029.6	43	20,029.6	40	8,464.9	37	7,293.3	86.2
2	Дэлгэрхаан	4	448.8	5	384.5	5	384.5	4	304.5	79.2
3	Жаргалтхаан	15	742.5	11	642.5	11	521.6	11	473.9	90.9
4	Баянмөнх	7	305.4	7	282.8	7	282.8	4	184.1	65.1
5	Дархан	28	938.4	28	938.4	28	938.4	24	786.8	83.8
6	Галшар	13	997.6	13	997.6	13	789.2	11	702.6	89.0
7	Баянхутаг	14	725.3	14	725.3	14	525.3	12	256.9	48.9
8	Биндэр	25	593.7	25	555.1	25	558.6	15	414.6	74.2
9	Баян-Адарга	14	601.0	14	601.0	14	475.2	10	343.2	72.2
10	Өмнөдэлгэр	21	1,862.3	21	1,510.5	21	1,489.1	13	713.8	47.9
11	Батширээт	14	612.2	15	445.8	15	431.8	13	335.4	77.7
12	Цэнхэрмандал	39	1,599.5	35	1,330.3	35	1,126.3	34	833.5	74.0
13	Мөрөн	11	623.1	10	528.1	10	486.9	10	343.9	70.6
14	Батноров	12	856.4	12	856.4	12	842.3	9	641.2	76.1
15	Баян-Овоо	18	658.2	18	655.8	18	485.4	11	287.9	59.3
16	Дадал	9	527.2	10	400.8	10	400.8	8	211.0	52.6
17	Норовлин	15	820.4	15	602.2	15	602.2	13	345.1	57.3
18	Бэрх	3	188.9	3	182.1	3	132.2	3	130.2	98.5
19	Бор-Өндөр	16	1,194.8	16	1,201.3	16	796.5	12	503.9	63.3

20	Хэрлэнбаян-Улаан	10	183.0	10	183.0	10	183.0	4	100.6	55.0
21	Өлзийт	3	203.9	3	203.9	3	76.2	2	33.0	43.3
22	Хэрлэн	19	3,246.4	19	2,766.6	16	1,246.9	16	1,069.4	85.8
23	Гурванбаян	8	208.4	10	180.4	10	180.4	8	96.5	53.5
	Нийт дүн	<b>361</b>	<b>38,166.8</b>	<b>357</b>	<b>36,204.0</b>	<b>351</b>	<b>21,420.6</b>	<b>284</b>	<b>16,405.3</b>	<b>76.6</b>

Гүйцэтгэлээр 284 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 16,405.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 76.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Төлөвлөсөн арга хэмжээнээс 67 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

**Хоршоог хөгжүүлэх сангийн зээл олголт 39.9 хувийн гүйцэтгэлтэй байна.**

Сумдын ИТХ-ын тогтоолоор Хоршоог хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг эхний үлдэгдлээс 2,477.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,132.9 сая төгрөг, нийт 3,610.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Үүний 3,556.7 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд, 54.4 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр зээлийн эргэн төлөлтөөр 1,197.6 сая төгрөгийг төвлөрүүлж, эргэн төлөгдөх зээлд 1,417.7 сая төгрөгийг олгосон байна.

#### Хоршоог хөгжүүлэх сангийн зээл олголт

Хүснэгт 18.

/ сая төгрөг/

Сумын нэр	Төл	Гүйц	Зөрүү	Хувь	Сумын нэр	Төл	Гүйц	Зөрүү	Хувь
Галшар	212.0	212.0	0.0	100.0	Баян-Адарга	113.5	0.0	113.5	0.0
Баянхутаг	127.5	0.0	127.5	0.0	Дадал	133.1	0.5	132.6	0.4
Баянмөнх	256.3	0.0	256.3	0.0	Норовлин	110.0	107.7	2.3	97.9
Дархан	84.2	0.0	84.2	0.0	Батноров	165.7	123.0	42.7	74.2
Дэлгэрхаан	153.1	0.2	153.0	0.1	Баян-Овоо	207.0	40.0	167.0	19.3
Жаргалтхаан	214.4	79.4	135.0	37.0	Мөрөн	133.6	114.3	19.3	85.5
Цэнхэрмандал	71.5	60.0	11.5	83.9	Хэрлэн	579.5	420.0	159.5	72.5
Өмнөдэлгэр	65.2	0.6	64.5	1.0	Гурванбаян	20.0	20.0	0.0	100.0
Өлзийт	0.0	0.0	0.0		Хэрлэнбаян-Улаан	9.9	0.0	9.9	0.0
Батширээт	100.0	0.0	100.0	0.0	Бор-Өндөр	460.6	240.0	220.6	52.1
Биндэр	100.0	0.0	100.0	0.0	Бэрх	239.0	0.0	239.0	0.0
					<b>Дүн</b>	<b>3556.1</b>	<b>1417.7</b>	<b>2138.4</b>	<b>39.9</b>

Хоршоо хөгжүүлэх сангаас 3,556.1 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс 1,417.7 сая төгрөгийн зээл олгож, Баянхутаг, Баянмөнх, Дархан, Батширээт, Биндэр, Баян-Адарга сум, Бэрх, Хэрлэнбаян-Улаан зэрэг 8 сум, тосгон зээл олгоогүй байна.

- Хэрлэнбаян-Улаан тосгон зээл олгох төслийн сонгон шалгаруулалт зарлаагүй.
- Баянхутаг сум зээл олгох зөвлөлийг байгуулж, зээл олгох журмыг ИТХ-аар батлаагүй.
- Биндэр, Батширээт, Баян-Адарга, Баянмөнх, Дархан сумд, Бэрх тосгонд Хоршоог хөгжүүлэх сангийн журмын шаардлагад нийцсэн хоршоологчид, зээлдэгчийн материал ирээгүйгээс шалтгаалжээ.

*Иймд Хоршоо хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийг орон нутагт шинээр үйлдвэрлэл бий болгох, жижиг дунд үйлдвэрлэлийг өргөжүүлж иргэдийн амьдралд бодит орлогыг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.*

**Орон нутгийн төсвийн нийт тэнцэл 2,277.6 сая төгрөгийн ашигтай гарсан байна.**

Хэнтий аймгийн 2025 оны төсвийн орлого, зарлагын тэнцлийг тэнцвэржүүлэн төлөвлөж, гүйцэтгэлээр 2,277.6 сая төгрөгийн ашигтай гарсан байна.

**Орон нутгийн төсвийн 2025 оны үр дүнгийн үзүүлэлт**

Хүснэгт 19.

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх 2024 оны гүйцэтгэл	2025 он			
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
А	1	2	4	5	6=5-4
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>107,289.3</b>	<b>123,822.2</b>	<b>118,188.4</b>	<b>104,293.5</b>	<b>(13,895.0)</b>
<b>А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>50,365.0</b>	<b>59,011.7</b>	<b>74,448.5</b>	<b>60,654.8</b>	<b>(13,793.6)</b>
1 Татварын орлого	42,750.4	38,194.7	40,759.8	51,269.3	10,509.4
2 Татварын бус орлого	5,708.7	2,627.6	4,091.0	6,696.4	2,605.4
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,905.9	2,851.8	2,522.9	2,689.1	166.2
Бусад тусламж /эхний үлдэгдлээс/	-	15,337.6	27,074.7	-	(27,074.7)
<b>Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>232.1</b>	<b>200.0</b>	<b>200.0</b>	<b>255.2</b>	<b>55.2</b>
<b>В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>56,692.2</b>	<b>64,610.5</b>	<b>43,540.0</b>	<b>43,383.4</b>	<b>(156.6)</b>
ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	17,914.6	23,761.1	16,234.2	16,077.6	(156.6)
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	38,777.6	40,849.4	27,305.8	27,305.8	-
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>93,909.3</b>	<b>123,822.2</b>	<b>118,188.4</b>	<b>102,015.9</b>	<b>(16,172.5)</b>
<b>А. УРСГАЛ ЗАРЛАГА</b>	<b>65,807.2</b>	<b>82,923.9</b>	<b>81,168.6</b>	<b>73,134.9</b>	<b>(8,035.6)</b>
1 <b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>63,117.6</b>	<b>81,181.0</b>	<b>79,601.4</b>	<b>71,834.3</b>	<b>(7,767.2)</b>
1.1. Цалин, хөлс	21,064.0	27,929.6	27,542.8	25,787.5	(1,755.3)
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	2,569.8	3,491.3	3,444.5	3,155.7	(288.7)
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	39,483.8	49,760.2	48,614.1	42,891.0	(5,723.1)
2 <b>Зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
3 <b>Татаас ба урсгал шилжүүлэг</b>	<b>2,689.6</b>	<b>1,742.9</b>	<b>1,567.2</b>	<b>1,300.7</b>	<b>(266.5)</b>
3.1. Татаас	399.0	321.7	15.0	2.0	(13.0)
3.2. Урсгал шилжүүлэг	2,290.6	1,421.2	1,552.2	1,298.7	(253.5)
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,029.7</b>	<b>36,414.5</b>	<b>32,463.8</b>	<b>26,463.3</b>	<b>(6,000.5)</b>
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>1,072.4</b>	<b>4,483.8</b>	<b>4,556.1</b>	<b>2,417.7</b>	<b>(2,138.4)</b>
1 Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	1,072.4	4,483.8	4,556.1	2,417.7	(2,138.4)
<b>УРСГАЛ ТЭНЦЭЛ</b>	<b>(15,442.2)</b>	<b>(23,912.2)</b>	<b>(6,720.2)</b>	<b>(12,480.1)</b>	<b>(5,758.0)</b>
<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>13,380.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2,277.6</b>	<b>2,277.6</b>

Тайлант онд татварын орлогоос 40,759.8 сая төгрөг, татварын бус орлогоос 4,091.0 сая төгрөг, хөрөнгийн орлого 200.0 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 2,522.9 сая төгрөг, урьд оны эхний үлдэгдлээс 27,035.8 сая төгрөг, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг 27,305.8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлгийн орлого 16,234.2 сая төгрөг, нийт 118,188.4 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж нэгдсэн төсвийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр татварын орлогоос 51,965.7 сая төгрөг, татварын бус орлогоос 6,696.4 сая төгрөг, хөрөнгийн орлого 255.2 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 2,689.1 сая төгрөг, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг 27,305.8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлгийн орлого 16,077.6 сая төгрөг, нийт 104,293.5 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,277.6 сая төгрөгийн ашигтай илэрхийлэгдсэн байна.

Тайлант онд татварын орлогын төлөвлөгөө 10,509.4 сая төгрөгөөр, татварын бус орлого 2,605.4 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 166.2 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна. Мөн урсгал зардлыг 8,035.6 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 6,000.5 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийн зардлыг 2,138.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай нь холбоотой байна.

Төсвийн урсгал орлогод 60,654.8 сая төгрөгийн эх үүсвэр бүрдэж, урсгал зардалд 73,133.0 сая төгрөгийг зарцуулснаар төсвийн урсгал тэнцэл 12,480.1 сая төгрөгийн алдагдалтай байна.

Өмнөх онтой харьцуулахад нийт тэнцэлийн ашиг 2,277.6 сая төгрөг болж 11,102.5 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оноос санхүүгийн дэмжлэг 11,471.8 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого 1,837.0 сая төгрөгөөр буурч, нийт зардал 8,106.7 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### **БҮЛЭГ 3. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ, ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛААГҮЙТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ ИЛЭРСЭЭР БАЙНА.**

*Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 1,454.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.*

УИХ-аас 2022 онд “Төрийн хэмнэлтийн тухай хууль”, Засгийн газраас 2021 онд “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, 2022 онд “хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар” 203, 204 дүгээр тогтоолуудыг баталсан.

Хуулийн хэрэгжилтийг ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хамааралтай шалгуур үзүүлэлтийн дагуу горим сорил гүйцэтгэхэд 1,454.3 сая төгрөгийн 18 зөрчил илэрч, 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,453.9 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 17 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

1. Батноров, Галшар, Дархан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах” гэж заасныг зөрчиж 1,185.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.
2. Баян-Адарга, Баянхутаг, Дархан сумдын ЗДТГ, Өндөрхаан хот тохижилт ОНӨҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана гэж заасныг зөрчиж цахим тендер зарлалгүй 178.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.
3. Баян-Адарга, Баян-Овоо, Дадал, Өмнөдэлгэр, Норовлин сумдын ИТХ, Цэнхэрмандал, Дархан сумдын ЗДТГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8 “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно” гэж заасныг зөрчин 36.9 сая төгрөгийг зарцуулсан байна.
4. Өндөрхаан хот тохижилт ОНӨҮГ- нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 нөөцлөх шаардлагатай бараа материалыг үр ашиггүй, удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх нөөцлөх” гэж заасныг зөрчин 54.1 сая төгрөгийн материалыг нөөцөлсөн байна.

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хангаж ажиллаагүй 20 байгууллага байна.*

ТЕЗ-ийн харьяа байгууллагын хувьд санхүүгийн тайланд хийсэн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 10,245.4 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг таслан зогсоох 20 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

- Баян-Овоо ЗДТГ – 462.5 сая
- Баян-Овоо ИТХ – 46.3 сая
- Баянмөнх ИТХ – 190.9 сая
- Мөрөн ЗДТГ – 237.9 сая
- Мөрөн ИТХ – 43.7 сая
- Хэрлэн ЗДТГ – 3,956.4 сая
- Цэнхэрмандал ЗДТГ – 1,219.8 сая
- Цэнхэрмандал ИТХ - 134.7 сая
- Аймгийн ЗДТГ – 1,097.4 сая
- Батширээт тохижилт- 11.5 сая

- Өндөрхаан хот тохижилт ОНӨҮГ – 566.6 сая
- Батноров, Батширээт, Баянмөнх, Биндэр, Хэрлэнбаян-Улаан, Цэнхэрмандал, Өлзийт, Бэрх, Дархан сумдын ОНХС-ууд 2,277.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийг авч үзэхэд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 465.6 сая төгрөгийн 2 зөрчил илэрч байсан бол тайлант онд 10,245.4 сая төгрөгийн 20 зөрчил болж 10 дахин өссөн байна.

**Өмнөх аудитаар өгсөн аудитын 6 шийдвэрээс 5 шийдвэр буюу 83.3 хувь бүрэн хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 1,725.4 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс 1725.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, зөрчлийг арилгах 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитаар хүргүүлсэн 3 албан шаардлага бүрэн хэрэгжиж, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, “Татварын орлогыг төлөвлөхдөө судалгаа, тооцоонд үндэслээгүй, нөөц боломжийг бүрэн дайчлаагүйгээс 14,102.6 сая төгрөгөөр давсан байна” гэсэн зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

#### **Нэгдсэн судалгааны талаар:**

##### **1. Программ хангамжийн талаар:**

ТЕЗ-ийн харьяа байгууллагууд 72 программын мэдээлэл нэгтгэгдсэн байна. Судалгаагаар 121.8 сая төгрөгийн 57 программыг нягтлан бодох бүртгэл тусгасан байна. Үүнээс 85.0 сая төгрөгийн үнэ бүхий 46 программыг үйл ажиллагаандаа ашиглаж, үйл ажиллагаанд ашигладаггүй 36.8 сая төгрөгийн 11 программ байна. Мөн нягтлан бодох бүртгэлд тусгаагүй боловч үйл ажиллагаандаа 15 программыг ашиглаж байна. Нийтлэг ашиглаж байгаа программ нь нягтлан бодох бүртгэл, архивын программууд байна.

##### **2. Унаа, хоолны хөнгөлөлтийн талаар:**

ТЕЗ-ийн хүрээнд нийт 71 байгууллагаас 50 байгууллага хоолны хөнгөлөлт олгож, 21 ОНӨҮГ-ууд хоолны хөнгөлөлт олгодоггүй байна. Хоолны хөнгөлөлтийг олгодог байгууллагууд өдрийн 5000-18000 төгрөгийг олгож байна. Хамгийн өндөр буюу нэг өдрийн 18,000 төгрөгийн хөнгөлөлтийг аймгийн ИТХ ажилчдадаа олгож байна.

##### **3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд зарцуулсан хөрөнгийн талаар:**

Тайлант онд ТЕЗ-ийн харьяа байгууллагууд сургалт, семинар, зөвлөгөөнд 568.8 сая төгрөгийн 182 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлээр 185 арга хэмжээг хэрэгжүүлж 511.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

##### **4. Гадаад албан томилолт, арга хэмжээний талаар:**

Дадал сумын ЗДТГ-аас Япон улсаас ирсэн зочид төлөөлөгчдийг хүлээж авахтай холбоотой 4.8 сая төгрөгийн зардал, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас БНСУ-д болсон аялал жуулчлалын чуулга уулзалтад оролцох төлөөлөгчдийн замын зардалд 18.6 сая төгрөг, нийт 23.4 сая төгрөгийг гадаад арга хэмжээний зардалд зарцуулсан байна.

##### **5. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын талаар:**

ТЕЗ-ийн харьяа байгууллагад төрд учирсан хохиролтой холбоотой гарсан зардал байхгүй.

#### 6. ОНӨҮГ-ын судалгаа:

ТЕЗ-ийн харьяа орон нутгийн өмчит 22 байгууллага үйл ажиллагаа явуулснаас 11 байгууллага 428.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. ОНӨҮГ-ууд 2025 онд нийгмийн хариуцлага, хөрөнгө оруулалт, бусад хэлбэрээр хөрөнгө зарцуулаагүй байна. Сургалт, семинар, албан томилолтын зардалд 9.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

#### 7. Байгууллагын орон тооны талаар:

ТЕЗ-ийн харьяа байгууллагууд нь 2025 онд Монгол Улсын Засгийн газраас баримталсан 9 хувийн хэмнэлтийн хүрээнд орон тооны цомхотгол хийгээгүй байна.

#### 8. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл:

ТЕЗ-ийн харьяаны 6 байгууллага 64.8 сая төгрөгөөр хэвлэл мэдээллийн байгууллагаас үйлчилгээ авахаар гэрээ байгуулсан байна. Үүнд: аймгийн ИТХ, Норовлин сумын ЗД, Норовлин сумын ЗДТГ, Байгаль орчны газар, Бэрх тосгоны захирагчийн ажлын алба, Баянмөнх сумын ЗДТГ байна.

### ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил:

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 393.6 сая төгрөгийн 9 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан байна. Дээрх алдааны 97.5 хувь нь мэдээллийг буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой, 2.5 хувь нь мэдээллийг тусгалгүй орхигдуулсантай холбоотой байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 15,644.3 сая төгрөгийн 177 зөрчил илэрснээс 63.7 сая төгрөгийн 25 төлбөрийн акт, 14,685.4 сая төгрөгийн 134 албан шаардлага, 890.4 сая төгрөгийн 17 зөвлөмж, 4.8 сая төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж шийдвэрлэсэн байна.

Нийт зөрчлийг байгууллагын ангиллаар авч үзвэл 15.8 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал, 29.9 хувийг ЗДТГ, 9.6 хувийг ОНХС, 13.0 хувийг бусад байгууллага, 31.6 хувийг сумын ТТЗ-чидтай холбоотой байна.

#### Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэл

Хүснэгт 20.

Зөрчил	тоо	дүн	/сая төгрөг/
			хувь
Төсвийн төлөвлөлттэй холбоотой	22	921.8	35.5
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	21	798.1	30.7
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	36	453.1	17.4
Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан	24	282.1	10.9
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	28	754.2	29.0
Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой	2	48.2	1.9
Худалдан авах ажиллагаатай холбоотой	2	579.9	22.3
Санхүүжилттэй холбоотой	4	107.2	4.1
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20	10,245.4	394.6
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18	1,454.3	56.0
<b>Дүн</b>	<b>177</b>	<b>15,644.3</b>	<b>602.5</b>

## Аудитын илрүүлэлт:

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 220.5 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрч, орон тоог бүрэн тайлагнаагүй 1 алдааг аудитын явцад залруулж, 220.5 сая төгрөгийг зөрчлийг арилгах 2 зөвлөмж хүргүүлээ.

1. Тайлант онд төсвийн тодотгол 1 удаа хийсэн боловч аймгийн ТЕЗ-ийн төсвийг төлөвлөхдөө урьд оны замын сангийн үлдэгдэл 105.1 сая төгрөг, малыг эрсдэлээс хамгаалах сангийн үлдэгдэл 115.4 сая төгрөг, нийт 220.5 сая төгрөгийн үлдэгдлийг дутуу төлөвлөж эх үүсвэрийг бүрэн дайчлаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлээ.

2. Өмнөдэлгэр ой анги ОНӨҮГ-т 5.4 сая төгрөг, Батширээт ой анги ОНӨҮГ-т 3.5 сая төгрөгийг батлагдсан санхүүжилтээс илүү олгосон, Сумдын орон нутгийн ерөнхий орлого, хоршоог хөгжүүлэх сан, сумдын ОНХС-ийн урьд оны үлдэгдэл 475.4 сая төгрөгийг төсөвт бүрэн төлөвлөөгүй, өмнөх оны эхний үлдэгдлээс санхүүжих хэсэгт Хэрлэн сумын ОНХС 83.5 сая, Батноров сумын ОНХС 5.0 сая төгрөг, Өмнөдэлгэр сумын орон нутгийн ерөнхий орлогыг 271.9 сая төгрөг, нийт 360.4 сая төгрөгөөр эхний үлдэгдлийн дүнгээс илүү төлөвлөж баталсан зэрэгт хяналт тавьж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлээ.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, Батширээт сумын ЗДТГ, Батширээт ой анги, Норовлин сумын ЗДТГ, Баян-Овоо сумын ИТХ, Дадал сумын ИТХ, ЗДТГ, Мөрөн сумын ИТХ, ЗДТГ, Хэрлэн сумын ИТХ зэрэг 10 байгууллага 122 орон тооны гүйцэтгэлийг тайлагнаагүй, улсын төсвийн 3 байгууллага 47.5 орон тоог илүү тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Тайланд залруулга хийсэн.

## Аудитын дүгнэлт

Аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр **104,293.5** сая төгрөгийн нийт орлого ба тусламж, **102,015.9** сая төгрөгийн нийт зарлага ба зээлийн дүнг аудитаар баталгаажуулав.

1. Орон нутгийн төсвийн урсгал тэнцэл 12,480.1 сая төгрөгийн алдагдалтай, нийт тэнцэл 2,277.6 сая төгрөгийн ашигтай гарсан байна.
2. Татварын орлогын төлөвлөгөөг 51,269.3 сая төгрөгөөр буюу 125.8 хувиар биелсэн нь орон нутгийн орлогыг нэмэгдүүлж төлөвлөх нөөц боломж байгааг харуулж байна.
3. ОНХС, Төрийн сангийн ерөнхий орлогын дансны урьд оны үлдэгдлийг Өмнөдэлгэр, Батноров, Хэрлэн сумд 360.4 сая төгрөгөөр илүү төлөвлөж, алдагдалтай төсөв баталсан байна.
4. ТЕЗ нь замын сан, малыг эрсдэлээс хамгаалах сангийн 220.5 сая төгрөг, 17 сум нь орон нутгийн ерөнхий орлого, ХХС, ОНХС-ийн 475.4 сая төгрөг, нийт 695.9 сая төгрөгийн урьд оны үлдэгдлийг төсвийн эх үүсвэрт төлөвлөөгүй байна.
5. Төсвийн төлөвлөлт, орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой 5,398.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь нийт төсвийн 4.6 хувийг эзэлж байна.
6. Шилэн данстай холбоотой ТШЗ, ОНӨҮГ, ОНТС зэрэг 20 байгууллагад 10,245.4 сая төгрөгийн зөрчил илэрч Шилэн дансны тухай хуулийн нээлттэй байх, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай, үнэн зөв мэдээлдэг байх зарчмыг хэрэгжүүлээгүй байна.
7. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь 91 хувьтай хэрэгжсэн байна.
8. Хоршоог хөгжүүлэх сангаас олгох зээлд 3,556.1 сая төгрөгийг төлөвлөснөөс 60.1 хувь буюу 2,138.4 сая төгрөгийн зээлийг олгоогүй байгаа нь төсөл сонгон шалгаруулах зөвлөл байгуулагдаагүй, ирүүлсэн төсөл нь журмын шаардлага хангаагүй, зээлийн эргэн төлөлт нь сангийн 30 хувьд хүрээгүйтэй холбоотой байна.

## Аудитын зөвлөмж

Аймгийн засаг даргад:

1. Урьд оны үлдэгдэл, татварын болон татварын бус орлогыг бүрэн тооцож, аймгаас сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулан төсвийн төлөвлөлтийг сайжруулах
2. Харьяа байгууллагуудын шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, бүрэн байршуулсан эсэхэд хяналт тавьж ажиллах

## Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Б	1	2	3=1-2	4=2/1
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>118,188.4</b>	<b>102,015.9</b>	<b>16,172.6</b>	<b>86.3</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>81,168.6</b>	<b>73,134.9</b>	<b>8,033.7</b>	<b>90.1</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>79,601.4</b>	<b>71,834.2</b>	<b>7,767.2</b>	<b>90.2</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,542.8	25,787.5	1,755.3	93.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,444.5	3,155.7	288.7	91.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,237.5	20,000.7	2,236.8	89.9
Хангамж, бараа материалын зардал	1,569.9	1,235.3	334.7	78.7
Нормативт зардал	99.5	57.4	42.1	57.7
Эд хогшил, урсгал засварын зардал	3,251.0	2,889.9	361.1	88.9
Томилолт, зочны зардал	890.6	717.5	173.1	80.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,137.6	11,762.0	1,375.6	89.5
Бараа үйлчилгээний бусад зардал	7,428.0	6,228.2	1,199.8	83.8
<b>ТАТААС</b>	<b>15.0</b>	<b>2.0</b>	<b>13.0</b>	<b>13.4</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	15.0	2.0	13.0	13.4
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,552.2</b>	<b>1,298.7</b>	<b>253.5</b>	<b>83.7</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	278.0	270.6	7.4	97.3
Бусад урсгал шилжүүлэг	1,274.2	1,028.1	246.1	80.7
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>32,463.8</b>	<b>26,463.3</b>	<b>6,000.5</b>	<b>81.5</b>
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>4,556.1</b>	<b>2,417.7</b>	<b>2,138.4</b>	<b>53.1</b>
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>118,188.4</b>	<b>114,816.4</b>	<b>3,372.1</b>	<b>97.1</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>118,188.4</b>	<b>114,816.4</b>	<b>3,372.0</b>	<b>97.1</b>
Орон нутгийн төсвөөс	72,403.7	96,049.2	(23,645.5)	132.7
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	16,234.2	16,077.6	156.6	99.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,132.9	1,217.8	(84.9)	107.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,398.6	1,471.8	(73.3)	105.2
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	27,019.2		27,019.2	0.0

## Аудит хийгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/сая төгрөгөөр/

Дансны нэр, төрөл		Тайлант он дүн
<b>1.1.1.1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>3,163.4</b>
<b>1.1.1.1.1</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,163.4</b>
<b>1.1.1.1.1.1</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>3,163.4</b>
<b>1.1.1.1.1.1.1</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	<b>3,163.4</b>
<b>1.1.1.1.1.1.1.1</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,163.4</b>
<b>1.1.1.2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,737.1</b>
<b>1.1.1.2.1</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,693.7</b>
<b>1.1.1.2.1.1</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,678.2</b>
1.1.1.2.1.1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51.5
1.1.1.2.1.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6.0
1.1.1.2.1.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6.1
1.1.1.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	135.8
1.1.1.2.1.1.5	Нормативт зардал	0.8
1.1.1.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	147.2
1.1.1.2.1.1.7	Томилолт, зочны зардал	38.3
1.1.1.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	382.2
1.1.1.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	1,910.5
<b>1.1.1.2.1.4</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15.5</b>
1.1.1.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	15.5
1.1.1.2.1.4.2.8	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15.5
<b>1.1.1.2.2</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>43.4</b>
1.1.1.2.2.1	Дотоод эх үүсвэрээр	43.4
1.1.1.2.2.1.4	Бусад хөрөнгө	43.4
<b>1.1.1</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>426.3</b>
1.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 426.3
1	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 426.3

